



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 30 өдөр

Дугаар 9/282

Мандалговь

Г Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Т  
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.5, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 5 дугаар тогтооолор батлагдсан журмын 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэх аж ахуйн нэгжүүдэд тусгай зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, түдгэлзүүлэх санал дүгнэлт гаргаж шийдвэрлүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай.

Дарга:	Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
Гишүүд:	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Хүнсний үйлдвэрлэл, худалдаа нийтийн хоолны хяналтын улсын байцааг Аймгийн Татварын хэлтсийн дарга Стандартчилал хэмжил зүйн хэлтсийн Чанарын шинжээч Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнсний үйлдвэрлэл, худалдаа, нийтийн хоолны асуудал хариуцсан мэргэжилтэн Аймгийн Цагдаагийн газрын Олон нийттэй харилцах албаны урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн Аймгийн Онцгой байдлын газрын Гал түймрийн хяналтын улсын байцааг

Хоёр. Холбогдох хууль, тогтоомж, стандарт, журмын хэрэгжилтэд хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг ажлын хэсэг (Засаг даргын орлогч)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



488190803